



БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/187

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.3.2 дахь заалт, 8.4 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гадаад улсын, эсхүл олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг боловсролын сургалтын байгууллагаас Монгол Улсын боловсролын сургалтын байгууллагад шилжин суралцах тохиолдолд суралцагчийн эзэмшсэн чадамжийг үнэлж, дүйцүүлэх, багц цаг тооцох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Захиргааны хэм хэмжээний актыг бүртгүүлэх ажлыг холбогдох хуульд заасан шаардлагын дагуу гүйцэтгэхийг Хууль, эрх зүйн хэлтэс (Г.Олонбаяр)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан журмыг өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээний хөгжлийн газар (Б.Лхагвабаяр), аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Х.Чинтогтох)-т даалгасугай.

ДАРГА

Т.НЯМ-ОЧИР

2024/12/12

ГАДААД УЛСЫН, ЭСХҮЛ ОЛОН УЛСЫН ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛДЭГ БОЛОВСРОЛЫН
СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГААС МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН
БАЙГУУЛЛАГАД ШИЛЖИН СУРАЛЦАХ ТОХИОЛДОЛД СУРАЛЦАГЧИЙН ЭЗЭМШСЭН
ЧАДАМЖИЙГ ҮНЭЛЖ, ДҮЙЦҮҮЛЭХ, БАГЦ ТООЦОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Энэхүү журмаар гадаад улсын, эсхүл олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг боловсролын сургалтын байгууллагаас Монгол Улсын боловсролын сургалтын байгууллагад шилжин суралцах (цаашид “шилжин суралцах” гэх) тохиолдолд суралцагчийн эзэмшсэн чадамжийг үнэлэх, дүйцүүлэх, багц цаг тооцохтой холбогдох харилцааг зохицуулна.

1.2. Журамд заасан “шилжин суралцах” гэдэгт гадаад улсын, эсхүл олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг боловсролын сургалтын байгууллагаас Монгол Улсын ижил түвшний сургалтын байгууллагад шилжин суралцахыг ойлгоно.

Хоёр. Ерөнхий боловсролын сургуульд шилжин суралцах хүсэлтийг шийдвэрлэх

2.1. Гадаад улсын, эсхүл олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг боловсролын сургалтын байгууллагаас Монгол Улсын ерөнхий боловсролын сургуульд шилжин суралцах суралцагчийн эцэг, эх асран хамгаалагчийн хүсэлтийг сургалтын байгууллага хүлээн авна.

2.1.1. Ерөнхий боловсролын сургуульд шилжин суралцах суралцагчийн хүсэлтийг сургалтын байгууллагын сургалтын менежер хүлээн авч, багш нарын бүлгийн хурлаар хэлэлцэж, тэмдэглэл хөтөлнө.

2.1.2. Шилжин суралцах суралцагчийн үнэлгээг дүйцүүлэхэд журмын 2.3-т заасан баримт бичгийг үндэслэх бөгөөд шаардлагатай тохиолдолд суралцагчаас мэдлэг, чадварын түвшнийг оношлох зорилгоор асуулга, ярилцлага, аман болон бичгийн шалгалт авч болно.

2.1.3. Энэхүү журмын 2.1.2-т заасан оношлох шалгалтын үр дүн нь суралцагчийг анги ухраах эсхүл үргэлжлүүлэн суралцуулахаас татгалзах үндэслэл болохгүй.

2.1.4. Шилжин суралцах суралцагчийн журмын 2.3-т заасан баримт бичгийг үндэслэн аргачлалын дагуу судлагдахуун хоорондын үнэлгээг дүйцүүлнэ.

2.1.5. Шилжин ирсэн суралцагчийн үргэлжлүүлэн суралцах ангийг тогтоохдоо, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлт, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан хугацааг үндэслэл болгож, энэхүү журмын аргачлалын дагуу түвшин хооронд дүйцүүлнэ.

2.2. Ерөнхий боловсролын сургуульд шилжин суралцахад түвшин, судлагдахууны үнэлгээний дүйцүүлэлт, агуулга нөхөн эзэмшүүлэх хичээлийн төлөвлөгөөг тогтоосон багш нарын бүлгийн хурлын шийдвэрийг сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.

2.3. Гадаад улсын, эсхүл олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг боловсролын сургалтын байгууллагаас Монгол Улсын сургалтын байгууллагад шилжин суралцах хүсэлт гаргахад дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

- 2.3.1. Суралцах хүсэлт /өргөдөл/;
 - 2.3.2. Суралцагчийн төрсний гэрчилгээ эсвэл иргэний үнэмлэхийн хуулбар;
 - 2.3.3. Гадаад улсын, эсхүл олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалтын байгууллагын тодорхойлолт, анги тус бүрд судалсан хичээлийн дүнгийн жагсаалт эх хувиар, түүний албан ёсны орчуулга;
 - 2.3.4. Ахлах ангид суралцах тохиолдолд суурь боловсрол эзэмшсэнийг гэрчлэх боловсролын баримт бичиг, эсвэл түүнтэй дүйцэх баримт бичгийн баталгаажуулсан хуулбар, албан ёсны орчуулга;
 - 2.3.5. Гадаад улсад суралцсан бол гадаад паспортын хувийн мэдээлэл бүхий хуудас, Монгол Улсын хилээр гарсан, орсон тухай тэмдэглэл бүхий хуулбар;
 - 2.3.6. Гадаад улсын иргэн бол Монгол улсад оршин суух зөвшөөрсөн үнэмлэх;
- 2.4. Сургалтын байгууллага нь шилжин суралцах хүсэлт гаргасан суралцагчийн журмын 2.3-т заасан баримт бичиг, 2.2-д заасан шийдвэрийн хамт боловсролын салбарын мэдээллийн системд бүртгэн, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад (цаашид “боловсролын газар” гэх) баталгаажуулах хүсэлт илгээнэ.
 - 2.5. Боловсролын газар нь 2.4-т заасан хүсэлт, шийдвэрийг нотлох баримтад тулгуурлан хянаж, ажлын 10 хоногт багтаан баталгаажуулна.
 - 2.6. Шилжин суралцах суралцагчийн сургалтын хөтөлбөр, судлах хичээлийн агуулгыг нөхөн эзэмшүүлэх шаардлагатай тохиолдолд эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэгтэйгээр төлөвлөгөө гаргаж, үе шаттай хэрэгжүүлэх, үнэлэх ажлыг сургалтын байгууллагын багш нарын бүлэг зохион байгуулна.
 - 2.7. Гүн ухаан /шашин/-ы чиглэлээр гадаад улсын төрөлжсөн сургалтын байгууллагад суралцсан суралцагч Монгол Улсын ерөнхий боловсролын болон тухайн чиглэлийн төрөлжсөн сургуульд шилжин суралцах хүсэлт гаргаж, хичээл, судлагдахууны дүнг дүйцүүлж болно.

Гурав. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад шилжин суралцах хүсэлтийг шийдвэрлэх

3.1. Гадаад улсын, эсхүл олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг ерөнхий боловсролын сургалтын байгууллагаас Монгол Улсын мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад шилжин суралцах суралцагчийн хүсэлтийг тухайн сургалтын байгууллага хүлээн авч, шийдвэрлэнэ.

3.2. Энэ журмын 3.1-д заасан хүсэлтийг сургалтын менежер ахлуулсан ажлын хэсэг хянан, дүгнэлт гаргана.

3.3. Ажлын хэсгийн дүгнэлтийг сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.

3.4. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь суралцагчийн өмнөх суралцаж байсан сургалтын байгууллагын баримт бичиг, чадамжийн үнэлгээ зэргийг үндэслэн мэргэжлийн боловсрол олгох хичээлийн үнэлгээг дүйцүүлж болно.

3.5. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад шилжин суралцах суралцагч нь энэхүү журмын 2.3-т заасны дагуу баримт бичгийг бүрдүүлсэн байна.

3.6. Шилжин суралцаж буй суралцагч нь бүрэн дунд боловсролын болон мэргэжлийн боловсролын агуулгыг бие даан нөхөн судалж, эзэмшсэн мэдлэг чадвар, чадамжаа үнэлүүлж болно.

3.7. Сургалтын байгууллага энэхүү журмын 3.2, 3.3, 3.5-д заасан дүгнэлт, захирлын тушаал, баримт бичгийг үндэслэн шилжин суралцаж буй суралцагчийн мэдээллийг боловсролын нэгдсэн мэдээллийн цахим системд бүртгэнэ.

Дөрөв. Бусад

4.1. Тухайн суралцагчийн дасан зохицоход чиглэсэн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон зөвлөгөө, үйлчилгээг тухайн сургалтын байгууллагын хүүхэд хамгааллын баг /анги удирдсан багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч гэх мэт/ үзүүлнэ.

4.2. Гадаад улсын сургалтын байгууллагад сурагч солилцооны хөтөлбөрт хамрагдсан суралцагчийн үнэлгээг энэ журмын 2-т заасны дагуу дүйцүүлнэ.

4.3. Сургалтын хөтөлбөр, агуулгын зөрүүг нөхөн эзэмшүүлэх үйл ажиллагааны явц, үр дүнд сургалтын менежер хяналт тавьж ажиллана.

4.4. Сургалтын байгууллага нь шилжин суралцаж байгаа суралцагчийн дүйцүүлсэн болон агуулга нөхөн эзэмшүүлсэн үнэлгээг хувийн хэрэг (үргэлжлүүлэн эсвэл нөхөн олгож)-т бичиж, баталгаажуулна.

4.5. Бүх шатны сургалтын байгууллагад шилжин суралцах иргэний бүрдүүлсэн материал, гаргасан шийдвэрийг сургалтын байгууллагын архивд хадгална.

4.6. Сурлагын үнэлгээнд өөрчлөлт оруулах, хууль бусаар баримт бичиг олгохыг хүсэх, шаардах зэрэг хууль бус аливаа үйлдлийг хориглоно.

Суралцагчийн эзэмшсэн чадамжийг үнэлж, дүйцүүлэх аргачлал

Ерөнхий боловсролын сургуулийн (1-12 ангид) түвшин бүрт харгалзан дүйцэх олон улсын сургалтын түвшний нэр, хөтөлбөр

Боловсролын түвшин	Анги	ОУ-ын сургалтын хөтөлбөрүүд										
		Primary	Lower Secondary			Upper Second	Advanced		IB	Pre-U
			Checkpoint-1	Checkpoint-2	Checkpoint-3	IGCSE/ O-level	AS	A-level				
Бага	1-р анги	■										
	2-р анги	■										
	3-р анги	■										
	4-р анги	■										
	5-р анги	■										
Суурь	6-р анги		■									
	7-р анги			■								
	8-р анги				■							
	9-р анги					■						
Бүрэн дунд	10-р анги					■						
	11-р анги						■					
	12-р анги							■	■	■		
Мэргэжлийн боловсрол	10-12 анги					■	■	■	■	■		

Олон улсын сургалтын зарим хөтөлбөрүүдийн үнэлгээг Монгол улсын сургалтын хөтөлбөрийн үнэлгээтэй дүйцүүлэхэд

Үнэлгээний шалгуурын дагуу дасгал даалгавраар сорил, шалгалт авах үед харгалзах түвшин		VI		III		II		I	
Үндэсний үнэлгээ A/425	Түвшин	VIII	VII	VI	V	IV	III	II	I
Primary	Хувиар	90-100	80-89	70-79	60-69	50-59	40-49	30-39	0-29
	Үгэн үнэлгээ	Excellent	Very Good	Good 65-80		Pass 50-65		Weak	
Checkpoint-I,II,III	Үсгэн үнэлээ	A	B	C	D	E	F	G	U
IGCSE		A & A*	B	C	D	E	F	G	U
AS		A	B	C	D	E	F	G	U
A-level		A & A*	B	C	D	E	F	G	U
IB /SL болон HL/ Russian	Тоон үнэлгээ	7	6	5	4				
		5	4	3	2	1			

Хэрэв 100 онооны схемээр үнэлдэг бол яг тэр хувиар нь дүйцүүлэх, харин 100 онооны схемээс өөр оноогоор үнэлдэг бол хувьд шилжүүлэх, хувиасаа харгалзах түвшинд шилжүүлэн дүйцүүлж болно.

Олон улс болон Монгол Улсын Бага боловсрол (1-5 дугаар анги)-ын судлагдахуун хоорондын дүйцүүлэлт

Хичээлийн нэр		Mongolian language	math	Science	Visual arts	music	Physical education	Health and wellbeing	English	Global Perspectives	Агуулгын зөрүү арилгах	Other
1	Бэлтгэл хөтөлбөр											
2	Монгол хэл											
3	Иргэний ёс зүйн боловсрол											
4	Математик											
5	Хүн ба Орчин											
6	Хүн ба байгаль											
7	Хүн ба нийгэм											
8	Дүрслэх урлаг, технологи											
9	Хөгжим											
10	Биеийн тамир											
11	Эрүүл мэнд											
12	Англи хэл											
...											

Олон улс болон Монгол Улсын Суурь, Бүрэн дунд боловсрол (6-12 дугаар анги)-ын судлагдахуун хоорондын дүйцүүлэлт

Хичээлийн нэр		Mongolian language	Literature	Mathematics	Additional Mathematics	Further Mathematics	Computer Science	ICT Or computing	Information Technology	Science Or Combined Science	Co-ordinated Sciences	Physics	Biology	Chemistry	Geography	Sociology	History	Music Or Drama	Art & Design	Design & Technology	Physical education	Health and wellbeing	English	Russian	Other Language	Агуулгын зөрүү арилгах	Economics	Accounting	Business Studies	Food & Nutrition	Global Perspectives	Digital Media & Design	Environmental Management	Drama	Бусад ...		
1	Монгол хэл																																				
2	Монгол хэл, бичиг																																				
3	Математик																																				
4	Математик																																				
5	Мэдээллийн технологи																																				
6	Байгалийн ухаан																																				
7	Байгалийн ухаан																																				
8	Байгалийн ухаан																																				
9	Байгалийн ухаан																																				
10	Нийгмийн ухаан																																				
11	Нийгмийн ухаан																																				
12	Нийгмийн ухаан																																				
13	Нийгмийн ухаан																																				
14	Урлаг																																				
15	Урлаг																																				
16	Дизайн технологи																																				
17	Дизайн технологи																																				
18	Биеийн тамир																																				
19	Биеийн тамир																																				
20	Гадаад хэл																																				

Энд нэр заагаагүй хичээл, судлагдахууны үнэлгээ, агуулга нөхөн эзэмшүүлэх эсэх дүгнэлт саналыг мэргэжлийн багш нарын бүлгийн хурлаар хэлэлцэж, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр баталгаажуулна.